

«ШИНЭ ТОЛЬ ХЭМЭЭХ БИЧИГ» СОНИНТОЙ ХОЛБООТОЙ
ЗАРИМ АСУУДЛЫГ ТОДРУУЛАХ НЬ

Т.Етекбай*

* Ном, хэвлэлийн түүх судлаач

Түлхүүр үг: төвд ном судар, монгол сонины хэвлэх үйлдвэр, сонины хэвлэлийн редактор, бие даасан чөлөөт хэвлэл, гурван улсын гэрээ, эрх чөлөөний хөдөлгөөн

2010 онд "Мон судар" хэвлэлийн газраас 1912 оны 8 дугаар сараас 1913 оны 5 дугаар сард Монгол дахь Оросын хаант засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчөөр ажиллаж байсан Иван Яковлевич Коростовецийн «Монголд өнгөрүүлсэн есөн сар» хэмээх номыг орос хэлнээс орчуулан хэвлүүлжээ.

И Я.Коростовецийн өдрийн тэмдэглэл хэлбэрээр бичсэн энэхүү ном нь Монгол Улс тусгаар тогтнолоо тунхагласны дараах үеийн Монгол, Оросын харилцаа, Монголын нийгэм, улс төрийн амьдралд болсон олон үйл явдлын талаар үнэн зөв хариулт өгөх бөгөөд, ялангуяа бидний энэ удаад онцлон сонирхсон «Шинэ толь бичиг» хэмээх хэвлэл анх яаж хэвлэгдсэн талаарх үнэн түүхийг сурвалжлан, уншигч олон түмэнд дэлгэн толилуулах боломж олгож байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

Өгүүлбээс, 1911 оны сүүлчээр Монгол оронд дэлхий дахины анхаарал татсан том үйл явдал болсон юм. Монгол даяар Манжийн дарангуйллын эсрэг эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж, тусгаар тогтнолын төлөө тэмцэгч ноёд, лам хуврагууд Жавзандамба хутагтын удирдлагаар улс орны бүх эрх мэдлийг Түр засгийн газарт шилжүүлж, Манж Чин улсаас Хүрээнд сууж байсан Сань До амбан сайдын яамыг татан буулгаж, өөрийг нь Монголоос хөөн явуулав. Цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн есөн, Европын 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Олноо өргөгдсөн Монгол Улс байгуулсныг ихэс дээдэс, лам, хар, ард олны сонорт албан ёсоор өргөн мэдүүлээд, Жавзандамба Богдыг Монгол Улсын наран гэрэлт, түмэн наст Богд эзэн, Дондогдулам Цагаан Дарийг Улсын Эх дагина хэмээн өргөмжилснийг зарлав. Энэ өдөр Богд хааны зарлигаар Монгол Улсын засгийн газрыг таван яамтайгаар байгуулж, улс орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэлд амь биеэ огоорон зүтгэгчдийг төрийг удирдах дээд албанаа тохоон томилж, өндөр зэрэг хэргэм шагнаан хүртээжээ.

Өмнө нь Жавзандамба хутагт болон ихэс ноёдоос эрх чөлөөнийхөө хөдөлгөөнийг дэмжүүлэхийн тулд Петербург руу хэдэн удаа элч төлөөлөгчдийг илгээж байсан ч Оросын тал тэднийг тун ч хайхрамжгүй хүлээж авч байжээ. Монголчуудын найдаж, итгэж байсан цорын ганц зүйл нь Оросын тусламж дэмжлэг байсан юм. Монголчууд тусгаар тогтнолоо тунхагласныхаа дараа Орост дахин хандсан ажээ. Монголоос болж Хятадтай муудалцах хүсэл Оросын хаант засгийн газарт байсангүй. Манж Чин улс, монголчуудын хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэхэд бэлэн байгаагаа Орос улс илэрхийлсэн байна. Гэвч 1912 оны эхээр Чин улс унаж, Хятадын Бүгд найрамдах улсыг тунхагласнаар энэ бүс нутагт явуулж байсан хаант Орос улсын бодлого өөрчлөгдөхөөс өөр аргагүй болов. 1912 оны 5 дугаар сарын 6, 14, 18-ний өдрүүдэд Оросын эзэнт гүрний томоохон сайд, түшмэлүүд оролцсон тусгай зөвлөлгөөнөөр Монголын асуудлыг гурвантаа авч хэлэлцжээ. Богд хааны засгийн газартай гэрээ байгуулах, Гадаад Монголыг Оросын эдийн засгийн ашиг сонирхлын хүрээ гэж хүлээн зөвшөөрөх, Хятадын талаар явуулах гадаад улс төрийн бодлогоо дээрх байдлыг иш үндэс болгон боловсруулахаар тус зөвлөлгөөнөөр тогтсон ажээ.

1912 оны 8 дугаар сарын 15-нд Монголын талаарх Оросын бодлого батлагдаж, Монголын засгийн газартай хэлэлцээр хийх бүрэн эрхт төлөөлөгчийн албан тушаалд дээрх тусгай зөвлөлгөөнүүдэд оролцож санал гаргаж байсан Иван Яковлевич Коростовец тохоон томилогдож нийслэл Хүрээ рүү мордсон ажээ. И.Я.Корос-

товец Богд хаант Монгол Улсын засгийн газартай хэлэлцээр хийсний эцэст 1912 оны 10 дугаар сарын 21-нд Орос, Монгол хоёр улсын Найрамдлын гэрээг Худалдааны протоколын хавсралттайгаар баталж гарын үсэг зурав. Орос-Монголын гэрээ хятадуудыг ихэд балмагдуулж, хамаг хэргийг Гадаад хэргийн сайд Лян Чжу-Хаод тохсоноор, түүнийг өөрчилж оронд нь Петербурgt элчин байсан Лу Цзен Цзяныг томилж, түүнд шинэ нөхцөл болзолтойгоор Оростой хэлэлцээр хийхийг зөвшөөрчээ. Уг асуудлын эцсийн шийдэл нь 1915 оны 5 дугаар сарын 25-нд гарын үсэг зурсан Гадаад (Ар) Монголын өөртөө засах эрхийн тухай Орос, Хятад, Монгол гурван улсын гэрээгээр батлагдаж, дуусгавар болсон түүхтэй юм. 1915 оны Хиагтын гурван улсын гэрээ ямар үр дагавар авчирсныг уншигч түмэн сайн мэдэх билээ.

Оросын дипломатч И.Я.Коростовец Монголын засгийн газартай хэлэлцээр хийх ажлаар 1912 оны 8 дугаар сараас 1913 оны 5 дугаар сар хүртэл есөн сар байсан ажээ. Энэ хугацаанд тэрээр хэлэлцээрийг үр дүнд хүргэхийн тулд Монгол Улсын засгийн газрын гишүүд, голлох ноён түшмэдүүд болон Богд Жавзандамба хутагттай хүртэл хэд хэдэн удаа уулзаж байжээ. Тэр үед Монголын томоохон феодал, ноёдын дийлэнх нь Орос улстай ойртох бодлогыг дэмжиж байсан хэдий ч тэдний дотор Хятад улсыг дагах бодолтой хүмүүс бас байсан ажээ. Нөгөө талаар Хятад улсын зүгээс монгол хэл дээр сонин сэтгүүл гаргаж Монголд тараахаар зэхэж байжээ. Энэ нөхцөлд Монголын жирийн ард түмнийг тэдний нөлөөнөөс хамгаалж, Орос улсын талд татахын

тулд нийт ардад гэгээрүүлэн сэнхрүүлэх ажил зохиох шаардлага тулгарсан байна. Тэр үед ард түмний оюун ухаанд шууд нөлөөлөх гол хэрэгсэл хэвлэлээс өөр байсангүй.

Иймд И.Коростовец Оросын бодлогыг ухуулан таниулах, монголчуудын оюун ухааныг сэнхрүүлэн ухааруулж, чухал мэдээллэр хангах зорилгоор сонин гаргах шийдвэрт хүрчээ. Дашрамд дурдахад Монголд монгол хэлээр гарсан анхны сониныг санаачлагч нь тэр үед нийслэл Хүрээнд Орос улсаас сууж байсан Ерөнхий консул Виктор Фёдорович Люба байсан гэж үзэх үндэстэй ажээ. 1912 оны 9 дүгээр сарын 12-нд В.Люба Оросын Гадаад хэргийн яамны нэгдүгээр газарт хандан айлтгал өргөж Оросын Ерөнхий консулын газрын дэргэд монгол хэлээр сонин гаргах санал тавьжээ. Хэвлэх үйлдвэр байгуулж, сонин хэвлэх мөнгө хөрөнгийг тэрээр Яамнаас хүссэн байна¹. Нэмж хэлэхэд, Петр Александрович Бадмаевын дэмжлэгтэй Монголд анх тараагдсан хэвлэл бол 1895-1897 онд Читад орос, монгол хэл дээр хэвлэгдсэн «Жизнь на восточной окраине» буюу «Дорнод хязгаарын амьдрал» нэртэй сонин байсан юм. Энэ сонин нь Буриад ба Монголын уншигчдад зориулагдсан бөгөөд улс орнуудын, ялангуяа оросын бодлогыг сурталчлах зорилготой байжээ².

И.Коростовец монголчуудад зориулж сонин гаргах асуудлаар хамгийн түрүүнд нь Нийслэл Хүрээнд суугаа Ерөнхий консул Виктор Фёдорович Любатай санал солилцжээ. Энэ тухай тэрээр 1913 оны нэгдүгээр сарын 2-ны өдрийн тэмдэглэлдээ: «Люба Бээжинд хэвлэгддэг хоёр монгол сэтгүүлийг надад үзүүлэв. Сэтгүүлийг барлах

аргаар хэвлэсэн агаад, цайран барын хэдэн сайхан зураг оруулсны дотор Юань Ши-Кайн (Хятад улсын ерөнхийлөгч) хөрөг, Оросыг Монголд хүчирхийлэл үйлдэж байгаагаар дүрсэлсэн шог зураг байлаа. Тэргүүн өгүүлэлд монголчуудыг хятадуудтай нэгдэхийг уриалжээ. Хавтсан дээр нь Хятад оронд оршин суудаг таван үндэстэн ястныг бэлэгдэн Бүгд найрамдах улсын таван өнгөт далбааг тавьсан байв. Сэтгүүлийн зорилго нь Монголд Бүгд найрамдах улсыг сурталчлан дэлгэрүүлэх, Оросын нөлөөтэй тэмцэх явдал гэдэг нь илт харагдаж байлаа. Уг сэтгүүлийг Монголд орж ирэхэд бид саад тавих ёстой гэж Люба үзэж байв. Ингэх нь хариу өгөх сулхан хувилбар, үүнээс арай идэвхтэй арга хэрэгсэл шаардлагатай гэж надад бодогдлоо. Хятадуудтай өөрсдийн нь зэвсгээр үзэлцвэл, өөрөөр хэлбэл орос үзэл санаатай монгол сонин юм уу, сэтгүүл бий болговол хамгийн сайн арга зам болно»³ гэж үзсэн ажээ.

Коростовецийн Любатай хийсэн уулзалт нь түүний монголчуудад зориулж сонин гаргах бодлыг нь бүр итгэл үнэмшилд хүргэж, эргэлт буцалтгүй болгожээ. Тэгэхэд Любагийн Коростовецэд үзүүлж байсан сэтгүүл нь Хятад улсаас монголчуудад зориулж хэвлэн гаргаж байсан «Монгол ер үгийн сэтгүүл» байсан бололтой. «"Монгол ер үгийн сэтгүүл"-ийг төрийн байгууллага шууд эрхлэн Бээжинд сар тутам гаргаж байсан бөгөөд яваандаа энэ сэтгүүл нь монгол төвдийн хэрэг шийтгэх журганы санаа бодлыг илэрхийлдэг болов. "Монгол ер үгийн сэтгүүл"-ийг 17х21 см-ийн хэмжээтэй, нүүр талдаа зөрүүлж зурсан Дундад улсын таван өнгийн далбааны

зурагтай, 90-100 хуудасны багтаамжтай монгол номын байдлаар монгол, хятад үсэг хавсран хэвлэж байв»⁴.

И.Коростовец сонин гаргах асуудлаар нийслэл Петербургийн их сургуулийн профессор В.Котвичид захидал бичиж, нийслэл Хүрэн дэх "Орос-Монголын комиссын агуулахын нөхөрлөл"-ийн ахлагч Ф.С.Москвитин, Хүрэн дэх орос сургуулийн багш Ц.Жамцарано (Ж.Цэвээн) нартай санал солилцож ярилцжээ. Ноён Коростовец 1913 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн тэмдэглэлдээ «Котвич (нэрт хятад судлаач, монголч эрдэмтэн, Петербургийн их сургуулийн суртал нэвтрүүлэгч) бидэнд редактор олж өгөх байх гэж бодож байв.

Сэтгүүлийн гол зорилго нь соён гэгээрүүлэх ажил байх ба ямарваа маргаан мэтгэлцээнээс ангид байх болно (Орос биш юм болгоныг гол нь муулах биш, харин итгүүлж үнэмшүүлэх замаар монголчуудыг бидэн рүү татах хэрэгтэй шүү дээ)⁵ гэж бичжээ. Эл тэмдэглэлд В.Котвичтэй сэтгүүлийн нийтлэл болон ажиллах хүмүүсийн талаар санал солилцсон нь илт байна.

Монгол сонин гаргах саналыг Ф.С.Москвитин бүрэн дэмжиж түүний зөвлөж хэлсэн үгийн тухай И.Коростовец тэмдэглэлдээ: «Монголчууд шинэ сонин мэдээ сэлтэд их дуртай улс учир уншигчид олдоно гэж тэрээр үзэж байв. Одоо монголчуудын гар дээр хуучны төвд ном судар, хятад

сониноос өөр юм алга. Харин Харбинд (Дорнод Хятадын төмөр замын хүч хөрөнгөөр) монгол сонин хэвлэгддэг, ганц-нэг дугаар нь энд ирдэг хэдий ч эндхийнхэнд ойлгомж муутай цахар аялгаар гардгаас гадна дэндүү номын хэлээр бичсэн материалтай ажээ. Москвитины энэ санааг ашиглаж ажил хэрэг болгох юмсан гэж бодогдож байсан ч сонин хэвлэх ажлыг хэн л

барьж аваа аж даа»⁶ гэж боджээ. Коростовец монголчуудын доторх мэдээллийн хэрэгцээг ийнхүү судлахын зэрэгцээ, сонин хэвлэх машин техникийг мөн сонирхож эрэл хайгуул хийж явжээ.

1912 оны намар Оросын худалдаачид Монголд хэв-

«

Энэ үед Монголд сонин сэтгүүл гаргаж ашиг олох боломж байгааг Оросын худалдаачин анзаарсан хэдий ч, яаж гаргах, юу нийтлэх талаар мэдлэг тун бага байжээ. Ийм учраас тэрээр Бүрэн эрхт төлөөлөгч

И.Я.Коростовецийн ирэхийг хүлээж байсан ажээ.

»

лэх үйлдвэр байгуулж ажиллуулахаар хэвлэлийн машин төхөөрөмж оруулж ирсэн ажээ. Үүнийг тэр үед нийслэл Хүрэнд ажиллаж байсан Оросын худалдаачин Ф.Москвитины Санкт-Петербург дэх В.Котвичид 1912 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр бичсэн захидал нотолж байна. Тэрээр: «Хэсэг нөхдийн хамт би хэвлэлийн хороо байгуулж буй бөгөөд монгол үсгийн тэмдэгтийг санамсаргүй Эрхүүгээс олж авлаа. Одоо эхлээд хэвлэлийн хорооны зардлаар монгол хэдэн сонин үнэгүй гаргая. Дараа нь консулын газраар дамжуулан, хэрэв энд Коростовец ирэх бол, түүгээр дамжуулан сонинд улсаас тэтгэлэг гаргаж өгөхийг санал болгох бодолтой байгаа. Таныхаар, жилд хэдэн мянгын

(рублийн) тэтгэлэг авах боломж гарах бол оо, аль эсвэл тийм боломж гарахгүй болов уу»⁷ гэж бичиж байжээ. Өөрөөр хэлбэл, энэ үед Монголд сонин сэтгүүл гаргаж ашиг олох боломж байгааг Оросын худалдаачин анзаарсан хэдий ч, яаж гаргах, юу нийтлэх талаар мэдлэг тун бага байжээ. Ийм учраас тэрээр Бүрэн эрхт төлөөлөгч И.Я.Коростовецийн ирэхийг хүлээж байсан ажээ. Харин И.Коростовец санхүүгийн дэмжлэг үзүүлэх биш, харин өөрөө сонин гаргах бодолтой байгаа талаар түүнтэй санал солилцжээ.

Харин Ф.С.Москвитин хэвлэх машинуудаасаа худалдаж авахыг санал болгосон байна. Энэ тухай: «Орос сонин гаргана гэж авчирсан хэвлэх машинуудаас олж авах нь зөв»⁸ гэж тэрээр зөвлөлөө хэмээн тэмдэглэлдээ бичсэн байна. И.Коростовец монголчуудад зориулж сонин гаргахын тулд Монголд авчирсан хэвлэлийн машин хаана байгааг сонирхов. Эрхүүгээс захиалж авчруулсан хэвлэх машинуудыг монголчуудад их бууны анги салбар зохион байгуулж өгч байсан, сургагч офицер Малиновскийгээс олжээ. «Тэрээр орос сонин гаргах бодолтой явдаг ч мөнгө хөрөнгө нь хүрэлцэхгүй учир бүтээгүй явсан юмсанж. Хэвлэх машин болон үсгүүдийг худалдаж авсан, монгол сонин гарах хүсэл төрлөө. Зардал гарах учраас энэ санааг минь Петербург дэмжихгүй нь илэрхий болохоор эрсдлийг нь өөрөө хүлээн, бие дааж шийдвэрлэх болов»⁹ гэж Коростовец тэмдэглэлдээ бичжээ. Коростовец хувиасаа мөнгө гаргаж хэвлэх машин худалдаж авсан нь түүний дараагийн тэмдэглэлээр бүрэн нотлогдож байна.

1912 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн тэмдэглэлд «Монгол Улсын их бууны анхны ангийн үзлэгийн дараа Малиновский биднийг өөрийнхөө байгуулсан орос-монгол хэвлэх үйлдвэрийн нээлтэд урилаа. Хэвлэх машиныг бидний дэргэд шууд залган ажиллуулав. Хэвлэх үйлдвэр алгын чинээ хоёр жижигхэн өрөөтэй, нэгэнд нь Троицко-савскаас ирсэн орос дарга нь суух болжээ. Оргилуун дарс ууж, таатай үг хэлцгээлээ. Үнэндээ бол энэ хэвлэх үйлдвэр минийх бөгөөд Петербургт захиалсан монгол үсэг ирмэгц монгол сонин хэвлэх ажилд ашиглах юм. ...Монгол сонины хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжинд зориулж Малиновскийд 1000 рубль би өглөө»¹⁰ гэж бичжээ. Ийнхүү ноён Коростовец сонин гаргахын тулд хэвлэлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авчээ. Энэ тухай тэмдэглэлдээ: «Миний бие энэ зорилгоор (Малиновскийгоос) хэвлэх машин худалдан авч, Петербургээс монгол үсэг захиалсан билээ»¹¹ гэж дурдсан байна. Ийнхүү сонин хэвлэн гаргахад хэвлэх үйлдвэрийн талаасаа санаа зоволтгүй болжээ.

Москвитины дээр дурдсан тэр үед Монголд тараагддаг сонин бол Оросын талаас материалыг нь бэлтгэж, Дорнод Хятадын төмөр замын хүч хөрөнгөөр Харбинд хэвлэгддэг байсан «Монголын сонин бичиг» (1909-1918) хэмээх хэвлэл байжээ. Энэ сонин хоёр долоон хоногт нэг удаа хэвлэгдэж, Орос-Монголын худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, Оросын улс төрийн ба соёлын амьдрал, ололтыг Монголын ард түмний дунд сурталчлан таниулах зорилгоор үнэгүй тараагдаж байв. Тэр үед «Монголын сонин бичиг» Европын стандартын дүр төрхтэй.

Монгол улсын худалдаа үйлдвэрлэлийн сурталчилгааны цорын ганц хэвлэл байжээ. Сэтгүүлийн редакцийн зөвлөл орос, монгол, хятад, англи хэлтэн хүмүүсээс бүрэлдэж байсан бөгөөд захиалагчид нь зар сурталчилгаа өгдөг байгууллага, ажил хэрэгч хүмүүс байсан ажээ¹².

1909 онд "Монголын сонин бичиг"-ийн тухай Хятадын «Бейжин жибао» бичихдээ: «Харбины сониныг монголчууд сайнаар хүлээж авлаа. ...Манай колоничлолын яам Монголыг гэгээрүүлэх төлөвлөгөө боловсруулсан боловч юу ч хийсэнгүй. Бид оросууд юу хийсэн, яг тэрнийг хийх байсан юм»¹³ гэж бичжээ. Гэвч энэ сэтгүүл нь зөвхөн Оросын бүтээгдэхүүн байгаагүй, түүнийг зохион байгуулагч санаачлагчдын нэг нь Оростой хамтран ажиллагсдын талыг баримтлагч Монголын ноён Удай байжээ¹⁴. «Удай бол Өвөр Монголын засаг ноён. Түүний хошуунд Манжийн эсрэг хөдөлгөөн хүчтэй өрнөж, бусад хошуудыг ч бас татан оролцуулах болов. 1912 оны есдүгээр сард хятадууд Удай ноёны хошууг эзэлж, ноён өөрөө Өргөө рүү зугаджээ. Удай Өргөөнд ирээд Шүүх яамны дэд сайдын тушаалд томилогдож, 1913 оны сүүл, 1914 оны эхээр Орост очсон Монголын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оролцсон ба 1914-1915 онд Хиагтад болсон гурван улсын хэлэлцээрт оролцож байв»¹⁵. Мөн сонины хэвлэлийн редактор нь Өлзий (Харчины дунд хошууны харьяат) байсан бол, Харбины хэвлэх үйлдвэрт орос, монгол мэргэжилтнүүд ажиллаж байжээ. «1909 оны сүүлчээр оросууд Харбин хотод монгол хэл дээр "Монголын сонин бичиг"-ийг гаргаж эхлэхэд Хайсан гүн түүний эрхлэгчийн

нэгэн байсан юм. Энэ сонин олонд алдаршсан билээ»¹⁶. Дашрамд дурдахад, Хайсан гүн бол Монголын тусгаар тогтнолын төлөө идэвхтэй тэмцэгч байсан бөгөөд 1911 онд Петербургт очсон Монголын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оролцсон ба Монголын тусгаар тогтнолыг зарласны дараа Гадаад яамны дэд сайдаар томилогдон ажиллажээ.

И. Коростовец Ц.Жамцаранотой монгол сонины талаар ■ ярилцаж санал солилцохдоо Петербургт байгаа буриад Барадиныг редактороор нь томилох бодолтой байгаагаа хэлж, түүнд энэ талаар захиа бичсэн тухай дуулгажээ. Оросын бүрэн эрхт төлөөлөгчийн санаа бодлыг бүрэн хуваалцах хүн нь Базар Барадин гэдэг буриад иргэн хэмээн тооцож байсан бололтой. Харин Ц.Жамцараног уг сонин нь бие даасан, чөлөөт хэвлэл байх нь чухал гэсэн санал хэлсэн ажээ. И.Коростовец түүний саналтай холбогдуулан бичихдээ: «Сонины чиглэлийн хувьд нэг их чөлөөтэй, бие даасан байдалтай байж чадахгүй шүү гэдгийг Жамцаранод анхаарууллаа. Оросын нөлөөг нэвтрүүлж, буриадуудын салан тусгаарлах үзлээс түдгэлзэх хэрэгтэй болно л доо. Энд буриадуудгүйгээр аргалах аргагүй нь жаахан тиймхэн юм. Энэ хүн буриадуудын үзэл санааг баримталж хэрэгжүүлэх байх, тэгэхдээ буриадууд оросуудыг бодвол илүү сахилга баттай, үнэнч зан чанартай (бага юм шаарддаг) учир түүнтэй ажиллахад амар байх болно»¹⁷ гэж боджээ.

Монголчуудад зориулж тогтмол хэвлэл гаргахын тулд ноён Коростовецэд монгол хэлний өндөр мэдлэгтэй, шинжлэх ухааны бүх талын боловсролтой, бичиж боловсруулах чадвартай

хүн хэрэгтэй болсон нь мэдээж. Петербургийн их сургуулийн профессор В.Котвичийн сонины редакторт санал болгосон Б. Барадин нийслэл Хүрээнд хүрэлцэн ирсэнгүй. Шаардлага хангасан хүнийг юуны өмнө нийслэл Хүрээнд амьдардаг монгол хэл мэддэг орос хүмүүсийн дотроос хайсан боловч олдоогүй байна. Ийнхүү гаргах гэж буй сонины редактороор ажиллах боломжийн хүн олоогүй учраас буриад хүн ажиллуулах дургуй байсан боловч Коростовец Орос-Монголын гэрээний төсөл дээр хамтран ажиллаж байсан, мэдлэг чадварыг нь сайн мэдэх Жамцарано Цэвээнд хандахаас өөр арга байсангүй. Энэ тухай: «Энд би монгол сонин гаргаж байгаа ба Жамцарано гэгч мөн л буриад эрийг редактораар нь томиллоо. Монгол хэл мэддэг, энд ажиллаж чадах, басхүү архи уудаггүй орос хүн олох гэж бүтэн 4 сар хичээсэн билээ. Хамгийн гол нь, буриадуудын атганд орчихгүй байж, тэднийг ашиглаж чаддаг байх явдал чухал юм»¹⁸ гэж өөрийн бодлоо илэн далангүй бичжээ.

Жамцарано Цэвээний тухай тэрээр бичихдээ гэрээг нарийвчлан авч үзэх «ажилдаа туслуулах зорилгоор би Жамцараног урилаа. (Олон талын) өндөр боловсролтой, ухаантай энэ хүн (миний) хийж хэрэгжүүлж байгаа үйл хэргийн ач холбогдлыг сайн ойлгож байгаа бололтой. Тэрээр манай (орос) сургуульд монголчуудад орос хэл заадаг байв. Жамцарано Өргөөд Эрхүү хотоос ирсэн бөгөөд тэнд өөрийн хүсэл зоригоор бус, харин буриадуудын салан тусгаарлах үзлийг номлосон хэрэгт буруутгагдан очсон байжээ. Харин наашаа Ази судлалын хорооны

томилолтоор ирсэн аж. Миний хувьд тэр хүн монголчууд болон монгол хэлний өндөр мэдлэгтнийхээ хувьд хэрэгтэй байсан юм»¹⁹ гэж өгүүлсэн байна.

Тэр үед Буриадад Оросоос тусгаарлаж Монгол улстай нийлэх хөдөлгөөн өрнөж байсан учраас Коростовец өмнө нь энэ хөдөлгөөнийг дэмжиж идэвхтэй оролцож байсан Ж.Цэвээнээс нэлээд болгоомжилсон нь илт байна. Сонинд Цэвээнийг ажиллуулснаар гал дээр тос нэмсэн хэрэг болж магадгүй гэж тэр айж байжээ. Энэ бодлоо ч Цэвээнээс нуугаагүй, сайн ярилцаж тийм асуудал гарахгүй гэдгийг хоорондоо тохиролцсон бололтой. 1913 оны нэгдүгээр сарын 30-ны өдрийн тэмдэглэлдээ: «Миний хэвлэн гаргах гэж байгаа монгол сонин «Шинэ толь» нэртэй байх юм. Тус сониныг цэвэр, шинжлэх ухаанч шинж чанартай байлгахыг хүссэн Жамцарано энэ нэрийг бодож олжээ. Би түүнтэй санал нийлэхгүй байгаа бөгөөд сонин улс төрийн булантай, тухайн үеийн үйл явдлыг тусган харуулах ёстой гэж үзэж байв»²⁰ гэжээ.

Хэдийгээр Цэвээн Жамцарано сонины редактораар ажиллахыг зөвшөөрсөн боловч, нийтлэлийн бодлогын асуудлаар Коростовецтэй санал зөрж байсан нь энэ тэмдэглэлээс тодорхой байна. Түүний сонгосон тус сонины редактор Ц.Жамцарано «Шинэ толь» гэсэн нэрийг өгсөн нь монголчуудын тэмүүллийг шинэ ирээдүйд залан хөтлөх, шинэ амьдралыг тусган харуулах үүрэг зорилготой нь холбоотой байсан гэж үзэж болох аж. 1913 оноос Нийслэл хүрээнээ «Шинэ толь хэмээх бичиг»²¹ гэдэг сэтгүүл хэвлэгдэн гарах болоод улмаар «Шинэ толь»-ийн хороог (редакц) байгуулжээ. Хороо нь

сэтгүүлд хэвлэгдэх зүйлийг бичүүлэх, сэтгүүлээ хэвлүүлэх, борлуулах ажлыг эрхэлж байлаа.

Сонин хэвлэгдсэн тухай тэмдэглэлдээ: «"Шинэ толь" хэмээх монгол сонины маань анхны дугаар өнөөдөр хэвлэгдэв. 200 хувиар хэвлэсэн бөгөөд монголчууд өвөртөө (халаасандаа) хийж явахад тохиромжтойг нь бодолцон жижигхэн дэвтэр хэлбэртэй гаргасан. Худалдах үнэ нь 10 копейк. Петербургт захиалсан үсэг маань ирээгүй учир тааруухан үсгээр хэвлэсэн билээ»²² гэж Коростовец бичжээ. «Шинэ толь хэмээх бичиг» нэгдүгээр нүүртээ «Түмэн зүйлийг бадруулан элдэв ухааныг нэвтрүүлнэ» гээд, анхны дугаартаа «Олон монголчууд нэгэнт тулгар төр байгуулж, тусгаар улс болсноос хойш элдэв номд боловсорч, яаравчлан хүчтэй, чийрэг болохыг хичээвэл зохих тул манай бичгийн хороо гадаад олон улсын хэрэглэж буй зүйл бүрийн эрдмийг товчлон бичих, олон монголчуудын эрдэм сурахад нэмэр болно» гэж зорилгоо тодорхойлжээ.

И.Коростовец 1913 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн тэмдэглэлдээ: «"Шинэ толь" хэмээх монгол сонины маань анхны дугаар Гандан хийдийн лам нарын дунд нэлээд шуугиан тарьсан ажээ. Гуравдугаар сарын 6-ны өдрийн дугаарын агуулгыг толилуулбал: 1) Дэлхийн бөмбөрцөг, ертөнцийн хэсгүүд, цаг уурын бүсүүд, 2) Дэлхийн бөмбөрцөг дээрх төр улсууд, 3) Халуун, хүйтэн, салхи шуурга, үүл болон агаар мандлын үзэгдлүүдийн тухай, 4) Соёлын хэр хэмжээний (тэнүүлчин, нүүдлийн, суурин аж амьдралын) тухай, 5) Аянга, цахилгааны тухай, 6) Худалдаа наймаа ба зам харилцаа, 7)

Төр улс ба засаглалын хэлбэрүүд, 8) Орос-Монголын гэрээ, 9) Петербургт Монголын төлөөлөгчдийг хүлээж авсан нь, 10) Янз бүрийн: Дэлхийн бөмбөрцөг дээрх амьдралын хязгаарлагдмал байдлын тухай, арьс өнгө ба шашин шүтлэгийн тухай, амьдрал үргэлжлэх хугацааны тухай.

Дэлхий бөмбөрцөг хэлбэртэй тухай өгүүлсэн ертөнцийн бүтэц, зохион байгуулалтын тухай өгүүлэл лам нарын дургуйцлийг хамгийн их төрүүлжээ. Шарын шашны сургаал ёсоор дэлхий хавтгай хэлбэртэй, эргэн тойрон далайгаар хүрээлүүлсэн байдаг гэнэ. Тэрчлэн аянга, цахилгааны үүслийн тухай, жилийн улирлуудын тухай, өөр өөр улс орон дахь цагийн ялгааны тухай бичсэн зүйлүүд ч тэдний дургуйцлийг төрүүлжээ. Лам нар Хутагтад гомдол мэдүүлж, шашны сургаал номд тэрсэлсэн этгээдийн эсрэг ямар арга хэмжээ авах тухайгаа зөвлөлдөж буй аж. Оршин суугчдын мухар сүсэг, харанхуй байдлыг ашиглагч лам нарын нэр хүндийг унагаах санаа бодол өвөрлөж явдаг хэмээн Ц.Жамцараног тэд хамгийн ихээр буруутгаж буй бололтой»²³. «Шинэ толь хэмээх бичиг» сонины редактор өөрсдийнх нь нэр нэр хүндийг навсайтал унагааж байгаа талаар лам хувирагууд ихэд гомдоллон Хутагтад айлтгал мэдүүлсэн байв. «Би Ц.Жамцараногийн шинэчлэгч эрч хүчийг жаахан хазаарлах ёстой байж л дээ. Хамгийн хүчирхэг энэ давхрааныхныг өөрсдийнхөө эсрэг босгоё гэсэн бодол надад өчүүхэн ч байгаагүй юмсан»²⁴ хэмээн Коростовец харамсан өгүүлжээ. «Шинэ толь хэмээх бичиг»-ийн анхны дугаар хэвлэгдэн гарсан түүх ийм байна. И.Коростовецийн тэмдэглэлээс үзэхэд

«Шинэ толь хэмээх бичиг» хэвлэгдсэн нь Монголын үндэсний сэтгүүл зүй анх үүссэн явдалтай шууд холбоотой эсэхэд зарим талаар эргэлзээ төрөхөөр байгааг нуух юун.

«Шинэ толь хэмээх бичиг»-ийн анхны дугаарын нийтлэлээс эхэлж Монголын нийгмийн дээд давхарга, ялангуяа лам нарын дунд бухимдал, сандрал үүсэж, Богд хаанд гомдол мэдүүлж байсан нь үнэн ажээ. Үүнийг хурдан намжаах зорилгоор лам нарын үзэл бодлыг дэмжсэн бурхан багшийн сургаал, судар зэргийг нийтэлж байжээ. 1913 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн тэмдэглэхдээ: «Толстойн "Будда бурхан" гэдэг алдарт туужийг Жамцарано монгол хэлнээ орчуулсныг бид хэвлэх үйлдвэртээ хэвлэж, нэг копейкоор худалдаанд гаргалаа. Бараг ганц өдрийн дотор худалдагдаад дууссан бөгөөд одоо харин монголчууд нэг нэгнээсээ 20 копейкоор худалдан авч байгаа ажээ. Олж мэдэх гэсэн ямар их хүсэл тэмүүлэл, оюун ухааны яасан хомс тарчиг хоол тэжээл энд байна вэ!»²⁵ гэж Коростовец гайхан өгүүлсэн байна.

«Шинэ толь хэмээх бичиг»-ийг сэтгүүл, дэвтэр (товхимол), сонин хэмээн олон янзаар бичсэн байдаг. Аливаа хэвлэлийг ямар төрөлд хамаардаг болохыг хэлбэр, нийтлэлийн шинж чанар талаас нь тодорхойлж болдог. Хэлбэрийн талаас нь авч үзбэл, «Шинэ толь хэмээх бичиг»-ийн эхний дөрвөн дугаар нь 23х15 см хэмжээний 30-40 хуудастай номын маягаар хэвлэгдэж, дараагийн дугаарууд нь 34х26 см хэмжээний 6-10 нүүртэй сонин хэлбэрээр хэвлэгдэж, 1914 оны 8 дугаар сарын 21 хүртэл тус бүр 500 хувь, бүгд 20 дугаар уг

үйлдвэрт хэвлэгджээ²⁶. «Шинэ толь хэмээх бичиг»-ийн эхний дөрвөн дугаарын хэмжээ нь одоогийнхоор бол ном хэвлэдэг хэмжээ юм. Харин тав дахь дугаараас А-3 форматын тал буюу одоогийнхоор сэтгүүлийн хэмжээгээр хэвлэгдсэн байх юм.

Хэвлэлийг нийтлэлийн шинж чанар талаас нь авч үзэхэд сонин аль болох олон үйл явдлын тухай мэдээлэх шинж чанараараа ялгардаг, сэтгүүл нь аль нэгэн хүрээн доторх сэдвийг гүнзгий авч үздгээрээ онцлогтой, харин ном тодорхой нэг сэдвээр бичигддэг байна. Тэгвэл «Шинэ толь хэмээх бичиг»-ийн анхны дугаарт сэтгүүлийн шинж чанар нь хамгийн ихээр давамгайлж, түүний дараа номын шинж чанар нь орж байхад сонины шинж чанар нь хамгийн бага байжээ. Харин дараагийн дугааруудаас эхлэн сонины шинж чанар нь давамгайлах болж ном, сэтгүүлийн шинж чанарууд нь аажмаар багасч иржээ.

Эдгээр бүх шинж байдлаар нь нэгтгэн авч үзвэл Монгол улс тусгаар тогтносны дараа нийслэл Хүрээнд монгол хэлээр хэвлэгдсэн «Шинэ толь» бол анхны сэтгүүл, анхны ном, бас анхны сонин байжээ.

Ишлэл

¹ Коростовец И. Я. 2010. Монголд өнгөрүүлсэн есөн сар. УБ., 279 дэх тал.

² Чимитдоржиев Ш. Б. 1987. Россия и Монголия. М., с. 190.

³ Мөн тэнд, 242 дахь тал.

⁴ Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ., 18 дахь тал.

⁵ Мөн тэнд, 242-243 дэх тал.

⁶ Мөн тэнд, 130 дахь тал.

⁷ 1972. В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ., 251 дэх тал.

- ⁸ Мөн тэнд, 130 дахь тал.
- ⁹ Мөн тэнд, 150 дахь тал.
- ¹⁰ Мөн тэнд, 170-171, 178 дахь тал.
- ¹¹ Мөн тэнд, 242 дахь тал.
- ¹² Библиография Монголун Бичиг // Вести: Азии. Харбин, 1909, №1, с. 284.
- ¹³ Российский государственный исторический архив, ф. 323, оп. 1, д. 3199, л. 44.
- ¹⁴ Там же, с. 22-24.
- ¹⁵ Бурдуков А. В. 1987. Хуучин ба шинэ Монголд. УБ., 246 дахь тал.
- ¹⁶ Мөн тэнд, 242 дахь тал.
- ¹⁷ Мөн тэнд, 207 дахь тал.
- ¹⁸ Мөн тэнд, 314 дэх тал.
- ¹⁹ Мөн тэнд, 123-124 дэх тал.
- ²⁰ Мөн тэнд, 279 дахь тал.
- ²¹ Шинэ толь хэмээх бичиг оршив. Нийслэл хүрээ, 1913-1915.
- ²² Мөн тэнд, 330 дахь тал.
- ²³ Мөн тэнд, 346-347 дахь тал.
- ²⁴ Мөн тэнд, 45 дахь тал; Барон Б. Э. Нольде. 1930. Далекое и близкое. Исторические очерки. Изд. "Современные записки", Парис.
- ²⁵ Мөн тэнд, 354 дэх тал.
- ²⁶ Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ., 66 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Библиография Монголун Бичиг // Вести: Азии. Харбин, 1909, №1.
2. Бурдуков А. В. 1987. Хуучин ба шинэ Монголд. УБ.

3. Коростовец И. Я. 2010. Монголд өнгөрүүлсэн есөн сар. УБ.

4. Нольде Б. Э. 1930. Далекое и близкое. Исторические очерки. Изд. "Современные записки", Парис.

5. Российский государственный исторический архив, ф. 323, оп. 1, д. 3199.

6. Чимитдоржиев Ш. Б. 1987. Россия и Монголия. М.

7. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.

8. 1972. В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ.

9. Шинэ толь хэмээх бичиг оршив. Нийслэл хүрээ, 1913-1915.

Резюме

Статья посвящена вопросам возникновения и издания первой монгольской прессы — "Газеты, именуемой Новое зеркало" — родоначальника национальной журналистики Монголии. Автор, опираясь на новые исторические факты и информации, делает вывод о том, что эта газета была не только первой газетой и первым журналом, но и первой печатной книгой. Также в статье рассказывается о политическом, экономическом, социальном и международном факторах, которые оказали влияние на возникновение этой газеты.